



2021 оны 05 дугаар сарын 28  
№20 /1170/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ  
ᠬᠤᠷᠭᠢᠯᠠᠨ ᠠᠯᠪᠠᠨ  
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ  
ᠬᠤᠷᠭᠢᠯᠠᠨ ᠠᠯᠪᠠᠨ  
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠬᠤᠷᠭᠢᠯᠠᠨ

ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



## זיכרונות

זיכרונות מיימור מר יעקב

• זיכרונות מיימור מר יצחק בן-ציון (מיימור) מר 1907 ומר 9 מיימור) מר רחובות 9 ירושלים .  
 1907 - 1907 ומר 9 מיימור) מר מיימור מר מיימור

1906

• 1906

זיכרונות מיימור מר יצחק יעקב מר מיימור

מיימור יעקב מר מיימור מר 1907 ומר 9 מיימור  
 מיימור מר מיימור

מיימור 69

1906

• 1906

זיכרונות מיימור מר מיימור יעקב מר מיימור מר מיימור

זיכרונות מיימור מר מיימור מר מיימור יעקב מר מיימור . מיימור  
 מיימור יעקב מר מיימור מר מיימור מר מיימור  
 זיכרונות מר מיימור מר מיימור

מיימור 70

1906

• 1906



**ГАРЧИГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

- |      |   |  |      |
|------|---|--|------|
| 174. | Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай |  | 1499 |
|------|---|--|------|

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

- |      |   |           |      |
|------|---|-----------|------|
| 175. | Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 03 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 41 | 1503 |
|------|---|-----------|------|

**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ**

- |      |  |           |      |
|------|--|-----------|------|
| 176. | Монгол Улсын шүүхийн тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай | Дугаар 03 | 1528 |
|------|--|-----------|------|

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2021 оны 05 дугаар  
сарын 13-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН  
2022 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,  
2023-2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн үзүүлэлтийг доор дурдсанаар баталсугай:

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт		Төсвийн хүрээний мэдэгдэл	Төсвийн төсөөлөл	
		2022 он	2023 он	2024 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	4.6	6.3	6.4
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.0	6.0	6.0
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	13,206.4	14,515.2	15,958.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	28.9	28.8	27.6
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	14,852.0	15,925.1	17,113.3
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	32.5	31.6	29.6
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	900.4	1,073.0	1,188.2
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.0	2.1	2.1
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-1,645.6	-1,409.8	-1,154.9
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-3.6	-2.8	-2.0
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	3,768.9	4,151.5	4,761.2
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	8.2	8.2	8.2
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	27,073.7	27,961.9	28,984.7
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	59.2	55.5	50.2









## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 05 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар  
хот

### Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 03 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсэгт “... бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно.”, 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэгт “... Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно.”, 95.5 дахь хэсэгт “... Улсын Их Хурал энэ хуулийн 77.1, 77.2, 77.3, 77.4, 77.5, 77.6, 77.7, 77.8, 77.9, 77.10-т заасан журмыг баримтлан Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулж, томилно.” гэж заасан нь; мөн хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-77.11 дэх хэсэг, 95 дугаар зүйлийн 95.7 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 5, 6 дахь хэсгийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 03 дугаар дүгнэлтийг дараах үндэслэлээр хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

### ***Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг харгалзан үзээгүй талаар***

Монгол Улсын Их Хурлын нэр бүхий 62 гишүүн 2019 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бөгөөд 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн санал ирүүлж, төсөл өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 72 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, саналыг Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаа Улсын Их Хурлын нэр бүхий 62 гишүүнээс өргөн мэдүүлсэн төсөлтэй уялдуулах, асуудлыг зөвшилцөх үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ахлуулан байгуулж, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан.

Монгол Улсын Их Хурлын нэр бүхий 62 гишүүний өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах, нэмэлт өөрчлөлтийн төсөлд “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо нэр дэвшүүлэн томилгооны сонсгол хийж, Улсын Их Хурал хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар томилно. Тэдгээр нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан Монгол Улсын иргэн байна” гэсэн агуулгатай байсан бөгөөд хэлэлцүүлгийн явцад өөрчлөлт орсон хэдий ч Улсын Их Хурал томилох агуулга нь өөрчлөгдөөгүй юм.

Тодруулбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийг “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.” гэж өөрчилсөн. Өөрөөр хэлбэл, энэ зохицуулалтын агуулга нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус таван гишүүний сонгон шалгаруулалт нь хүн бүхэнд нээлттэй, ил тод байх, шаардлага хангасан гэж үзсэн хэн ч нэрээ дэвшүүлэх бололцоог олгож, олон нийтийн оролцоонд тулгуурлан хараат бусаар сонгон шалгаруулж, томилох боломжийг бүрдүүлнэ гэж хууль тогтоогчид үзсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэгт зааснаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлага, хэрхэн томилох журмыг хуулиар тогтоох нь Монгол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх юм. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнийг томилох журам, гишүүнд тавих шалгуур зэргийг Үндсэн хуульд заалгүй,<sup>1</sup> органик хуулиар тогтоох талаар тодорхой хэлэлцсэн болно.<sup>2</sup> Өөрөөр хэлбэл, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын

<sup>1</sup>Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл (УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Х.Нямбаатар); Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 9 дүгээр сарын 6-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл (УИХ-ын гишүүн О.Баасанхүү).

<sup>2</sup>Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 8 дугаар сарын 23-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл (УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан); Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 28-ны өдөр /Лхагва гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл (Ажлын дэд хэсгийн гишүүн О.Мөнхсайхан).

хорооны шүүгч бус гишүүнийг шүүхээс бусад институцийн тэнцвэртэй оролцоог хангаж нээлттэй нэр дэвшүүлэн сонгон шалгаруулж, томилох талаар үндэслэл бүхий бодлогын хувилбаруудаас сонголт хийж хуульчлах нь Монгол Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал төдийгүй Монгол Улсын Үндсэн хуульд тухайн харилцааг тусгайлсан хуулиар нарийвчлан зохицуулахаар заасан тохиолдолд хэрхэн хуульчлах нь Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх болох талаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэц урьд өмнөх олон удаагийн шийдвэртээ заасан байдаг<sup>3</sup>.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 03 дугаар дүгнэлтийн үндэслэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтын 3.1.1-д заасан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд тодорхойлогдсон Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус бусад таван гишүүнийг бусад институциэс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох талаарх чиглэлийг баримтлаагүй гэж үзэхээр байна. Ингэснээр шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус байдал болон Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.” гэж дүгнэсэн байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Их Хурлаас баталсан органик хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй бус харин Монгол Улсын Их Хурлын тогтоолд нийцээгүй байна гэсэн нэн тодорхойгүй үндэслэлийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2021 оны 03 дугаар дүгнэлтдээ заасан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуульд бусад институциэс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилохыг үүрэгжүүлсэн зохицуулалт байхгүй, харин Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилохыг хоёрдмол утгагүй хуульчилсан юм. Нээлттэйгээр нэр дэвшүүлэх гэдэг зохицуулалт нь аливаа институци, албан тушаалтны зүгээс хэн нэгэн хүнийг санал болгохгүй гэдэг утгыг агуулж байгаа төдийгүй олон нийтийг тэгш оролцох боломжоор хангана гэсэн агуулга юм.

<sup>3</sup>Жишээлбэл, Үндсэн хуулийн цэцийн 1993 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 04 дүгээр дүгнэлтэд “Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн зарим заалт, 33, 35, 36, 38 дугаар зүйлийн зарим заалтууд боловсронгуй бус байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4-т буй Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно гэсэн заалтын хүрээнд хуульчлагдсан тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралтын хуулийн нэгдүгээр зүйлийн 2-ын 2 дахь заалтаар Улсын Бага Хуралд олгогдсон хууль тогтоох эрх хэмжээнд шийдвэрлэгдсэн байна” гэж үзсэн.

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолыг агуулгын хувьд бүрэн хангасан талаар**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолын 3.1.1, 3.2.3 дахь заалтад Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүдийг бүрдүүлэхэд шүүхээс бусад институцийн тэнцвэртэй оролцоог хангах, нээлттэй нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, сонгон шалгаруулалтын үр дүнд томилох гэж тодорхой заасан нь хэн оролцож томилох тухай гэхээсээ илүүтэй ерөнхий зарчмын чиглэлүүд юм. Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ нь эдгээр чиглэлийг болон Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг бүрэн хангасан төдийгүй Монгол Улсын өнөөгийн нөхцөлд хамгийн сайн тохирсон, олон улсын сайн туршлагыг харгалзан үзсэн хувилбар юм.

**1.Шүүхээс бусад институцийн тэнцвэртэй оролцоог Ажлын хэсгээр хангах**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг хараат бусаар сонгон шалгаруулах Ажлын хэсгийг бүрдүүлэхэд шүүхээс бусад институцийн оролцоог тэнцвэртэй хангаж өгсөн. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсэг болон “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-ын 6 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн бүлэг, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хуралдаан, Монголын Хуульчдын холбооны Зөвлөл, Монголын Өмгөөлөгчдийн холбооны Удирдах зөвлөл, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургууль, төрийн бус өмчийн хууль зүйн сургууль тус бүрээс санал болгож Хууль зүйн байнгын хорооноос томилсон 10 хүн Ажлын хэсгийн гишүүнээр, Улсын Их Хурлын даргын томилсон Улсын Их Хурлын нэг гишүүн Ажлын хэсгийн ахлагчаар ажиллана. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцдог эдгээр байгууллага, түүний тодорхой бүтцүүд мөн мэргэжлийн болон сургалт, судалгааны байгууллага бол институци юм. Институци гэдгийг нийгмийн тодорхой зорилгыг хангах үүднээс үйл ажиллагаа явуулдаг зохион байгуулалт гэж ойлгодог.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны чиг үүргийг хамгийн сайн гүйцэтгэж чадах хүнийг сонгон шалгаруулах үйл явц нь хараат бус, бодитой, олон талын оролцоог хангасан байх шаардлагатай. Сонгон шалгаруулалтад аль нэг субъект давамгайлах боломжгүй байхаар буюу Ажлын хэсгийг 11 өөр институциас тэнцвэртэй бүрдүүлэхээр

хуульчилсан. Ажлын хэсгийн 11 гишүүний тав буюу цөөнх нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцдог институциудын тэнцвэртэй төлөөлөл учраас зүй бусаар нөлөөлөх эрсдэл үүсгэхгүй бөгөөд Ажлын хэсгийн бусад зургаан гишүүн буюу олонх нь мэргэжлийн төлөөлөл учраас сонгон шалгаруулалтыг хараат бусаар, мэргэжлийн өндөр төвшинд явуулах нөхцөл бүрдсэн.

## **2.Нээлттэй нэр дэвшүүлэх**

Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагаа нээлттэй, ил тод байх, олон нийтийн байгууллагын оролцоог хангаснаар сонгон шалгаруулалт болон томилгоонд аливаа зүй бус нөлөөллийг хаана гэж хууль тогтоогч үзсэн.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон “Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам”-д нээлттэй нэр дэвшүүлэх шаардлагыг бүрэн зохицуулсан бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг хангасан хэн ч нэр дэвших эрхтэй төдийгүй нэр дэвшигч бүрийн хүсэлт, дэлгэрэнгүй мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, иргэд, хуульчид, судлаачид асуулт, саналаа өгөх боломжийг бүрдүүлсэн.

## **3.Сонгон шалгаруулах**

Сонгон шалгаруулалт нь оролцогчийг хууль зүйн өндөр мэргэшилтэй мэдлэг, чадвар, ёс зүйтэй, эрх зүйч мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх зэрэг шалгуурыг мэдээлэл цуглуулах, ярилцлага гэх мэт олон талаас нь судалсны үндсэн дээр тухайн албан тушаалд хамгийн сайн тохирох хүмүүсийг шилж олох зорилготой юм. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүн нь хуульчаас шүүгчийг шилж олох, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хамгаалах чиг үүргийг гүйцэтгэх өндөр мэргэшилтэй, харин Шүүхийн сахилгын хорооны гишүүн нь шүүгчийн сахилгын хэргийг хараат бус, төвийг сахиж, шударгаар хянан шийдвэрлэх төвшний хууль зүйн өндөр мэргэшилтэй байх шаардлагатай. Шүүхээс бусад институциудын тэнцвэртэй оролцоог хангасан Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг хараат бусаар явуулж Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавигдах шаардлагыг хамгийн сайн хангасан нэр дэвшигчийг Улсын Их Хуралд санал болгохоор хуульчилсан.



#### 4.Томилгооны сонсгол

Ажлын хэсгийн сонгон шалгаруулалт хууль, журмын дагуу явагдаж Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд тавигдах шаардлагыг хамгийн сайн хангасан нэр дэвшигчийг тодруулсан эсэхийг Хууль зүйн байнгын хорооноос зохион байгуулах томилгооны сонсгол, Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хянан үзнэ. Олон нийтийн хяналт, оролцоо, ил тод байдлыг хангах үүднээс шалгарсан нэр дэвшигч бүрээр Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо томилгооны сонсгол хийхээр Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д тодорхой заасан. Томилгооны сонсголд Хууль зүйн байнгын хорооны гишүүдээс гадна сонирхсон иргэн, мэргэжлийн болон төрийн бус байгууллага, судлаач, хуульчид оролцож саналаа хэлэх, асуулт асуух замаар нэр дэвшигчийн талаарх мэдээллийг олон нийтэд өгнө.

Томилгооны сонсголыг хийснээс хойш ажлын таван өдрийн дотор Хууль зүйн байнгын хороо хуралдаж, нэр дэвшигч тус бүрээр хэлэлцэн санал хурааж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигчийг саналын дарааллаар эрэмбэлэн сул орон тооны тоогоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр томилуулах тухай Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх эрхгүй бөгөөд хуульд заасан шаардлагыг хангасан хүн нэрээ дэвшүүлэх эрхтэй юм. Түүнчлэн, тухайн нэр дэвшсэн иргэнийг Монгол Улсын Их Хурал шууд томилохгүй буюу Ажлын хэсэг хамгийн сайн шаардлага хангасан хүнийг олон нийтэд нээлттэй, ил тодоор сонгон шалгаруулж Улсын Их Хуралд санал болгох нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцнэ гэж хууль тогтоогч үзсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 03 дугаар дүгнэлтэд заасны дагуу Монгол Улсын Их Хурал Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг томилсноор шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус байдал болон Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлж байна гэж үзвэл нөгөө талдаа томилгоог хэн, хэрхэн хийх асуудал зүй ёсоор яригдана. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороо нь Үндсэн хуулийн байгууллага тул түүний томилгоог

хууль тогтоох, эсхүл гүйцэтгэх эрх мэдлийн Үндсэн хуулийн байгууллагад л хариуцуулах шаардлага гарна. Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно.” гэж заасан бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг санал болгох, томилох аливаа бүрэн эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгоогүй. Монгол Улсын Ерөнхийлөгч томилох боломжийг Монгол Улсын Үндсэн хуулиар хязгаарласан тул Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг гүйцэтгэх эрх мэдэл буюу Засгийн газар томилох нөхцөл үүснэ. Засгийн газрыг Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүнд олонх болсон намаас байгуулдаг учраас шүүх эрх мэдэл нэг намын хараат байдалд орох эрсдэл үүсэх, ингэснээр шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал алдагдахад хүрч болзошгүй юм. Түүнчлэн, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын албан үүргийг хавсран гүйцэтгэдэг байх зохицуулалт 1996 оноос 2002 оны хооронд мөрдөгдөж байсан бөгөөд үүнээс шалтгаалан олон сөрөг үр дагаварт хүргэж байна гэж үзэн өөрчилж байсан туршлага байдаг. Засгийн газар нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнадаг бөгөөд Ерөнхий сайд нь төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцдаг.

Нөгөөтээгүүр, Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүдийг Улсын Их Хурал томилох нь асуудлыг үзэмжээрээ шийднэ гэсэн үг биш бөгөөд Улсын Их Хурлын дур зоргыг хязгаарласан зохицуулалтыг олон улсын сайн туршлагад үндэслэн Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д хуульчилсан. Тодруулбал, сонгон шалгаруулалтыг шүүхээс бусад институцийн тэнцвэртэй төлөөлөл бүхий Ажлын хэсэг зохион байгуулах, Улсын Их Хурал олон нийтийн хяналт, оролцоо, ил тод байдлыг хангаж, шалгарсан нэр дэвшигч бүрээр томилгооны сонсгол зохион байгуулсны үндсэн дээр томилох эсэхийг шийдвэрлэхээр зааж, энэ бүх үйл ажиллагааг нарийн, тодорхой зохицуулсан нь дур зорго, зүй бус нөлөө орох эрсдэлийг бууруулна гэж хууль тогтоогч үзсэн болно.

***Гурав.Шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус байдал болон төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулаагүй талаар***

Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах зорилготой учраас үйл ажиллагаа нь харьцангуй бие даасан байх зарчмыг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д тодорхой заасан. Тодруулбал, Шүүхийн ерөнхий зөвлөл 10 гишүүнтэй байх бөгөөд даргаа гишүүд дотроосоо сонгохоор заасан нь Ерөнхий зөвлөлийн бие даасан байдлыг хангах, төдийгүй хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах зарчмын өөрчлөлт болсон.

Шүүхийн ерөнхий зөвлөлийг бүрдүүлэх болон хуульчдаас шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулж шүүгчээр томилуулах санал гаргах процессыг бүхэлд нь харвал аль нэг институци зүй бусаар илүү эрхтэй оролцох эрсдэлийг бууруулж, институциудыг тэнцвэртэй оролцох нөхцөлийг бүрдүүлсэн төдийгүй Шүүхийн ерөнхий зөвлөл хараат бусаар, хариуцлагатай ажиллах суурийг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д хуульчилсан. Түүнчлэн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн тавин хувь буюу таван гишүүнийг шүүгчид дотроосоо шууд сонгох нь шүүгчдийн оролцоог хангаж, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах төдийгүй аливаа зүй бус нөлөөллийг сааруулна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах Ажлын хэсэгт төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцдог институциуд, мэргэжлийн болон сургалт, судалгааны институциудын төлөөлөл, оролцоог тэнцвэртэй хангаснаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр зөвхөн мэдлэг чадвар, ёс зүйтэй хүнийг томилох нөхцөлийг бүрдүүлсэн. Шүүхийн ерөнхий зөвлөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хуульчдаас шилж олсон хүнийг шүүгчээр томилох, эсэхийг Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэдэг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн таван гишүүнийг шүүгчдээс сонгож бүрдүүлэх, шүүгч бус таван гишүүнийг олон талын оролцоотой, ил тод, нарийн процессоор бүрдүүлэхээр хуульчилсан нь төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг зөрчих бус харин хангах зохицуулалт болсон.

Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д Шүүхийн сахилгын хороо есөн гишүүнтэй байх бөгөөд дөрөв нь нийт шүүгчээс сонгогдсон шүүгч, тав нь шүүгч бус, хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан иргэд байхаар заасан. Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүнийг Нийт шүүгчийн чуулганаар сонгох бөгөөд үүнд Монгол Улсын Их Хурал болон аливаа этгээд оролцох боломжгүй юм. Сахилгын хорооны шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалт, томилгоо нь зарчмын хувьд Шүүхийн

ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах процесстой адил зохицуулагдсан учраас Улсын Их Хурал Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус таван гишүүнийг томилох, эсэхийг үзэмжээрээ шийдэх боломжгүй юм. Шүүхийн сахилгын хороог шүүгчийн хараат бус байдал болон хариуцлагын тэнцвэрийг харгалзан бүрдүүлэх болон энэ зарчмын хүрээнд ажиллах зохицуулалтыг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасан бөгөөд төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг алдагдуулахгүй, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг зөрчихгүй юм.

***Дөрөв.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн үндсэн зарчим, агуулгыг илтэд баримтлаагүй талаар***

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ” гээд мөн зүйлийн 1 дэх заалтад “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах” гэж, 2 дахь заалтад “төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох” гэж тодорхой хуульчилсан.

Монгол Улсын Их Хурал нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд шүүх эрх мэдлийг хэнээс ч хараат бусаар ажиллах нөхцөл, баталгааг бий болгож, мэдлэг чадвартай, ёс зүйтэй шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулах, шүүгчид хөндлөнгөөс нөлөөлөх, шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулахгүй байх эрх зүйн шинэтгэлийг Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д тусгасан бөгөөд хуулийн үзэл баримтлал, суурь зарчмын талаарх Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбарыг сонсолгүйгээр Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг зохион байгуулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуульд захирагдах, Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн хуулийг дээдлэх, судалгаанд үндэслэх, төвийг сахих, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж тодорхойлсон хэдий ч Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэхдээ судалгаанд үндэслэлгүй, төвийг сахих зарчмыг баримтлахгүйгээр хүсэлт гаргагчийн саналыг харгалзан шийдвэрлэсэн болох нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 03 дугаар дүгнэлтээс тодорхой харагдаж байна.



Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Цэц маргаан хянан шийдвэрлэхдээ хуралдааныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд илээр, шууд, тасралтгүй явуулах, талуудыг эрх тэгш, чөлөөтэй мэтгэлцүүлэх, асуудлыг хамтран хэлэлцэж, олонхийн саналаар, бодитой, энэ хууль болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд чанд нийцүүлэн шийдвэрлэх зарчмыг баримтална” гэж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Цэцийн хуралдаанд маргагч талууд, тэдгээрийн итгэмжилсэн төлөөлөгч, өмгөөлөгчид маргаж байгаа асуудлаар харилцан бие биедээ асуулт тавьж, хариулт авах, гомдлын шаардлага, татгалзлалын үндэслэл болсон нотлох баримтуудыг харилцан няцаах, энэ талаархи баримтуудыг зохих журмын дагуу гаргах, батлах зэргээр мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлнэ.” гэж заасныг тус тус биелүүлээгүй байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэн шалгаж байгаа гишүүн маргагч талуудад өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдлын хуулбарыг гардуулж, маргаанд оролцох итгэмжилсэн төлөөлөгчөө томилох тухай мэдэгдэх, маргагч талууд болон тэдгээрийн итгэмжилсэн төлөөлөгчийг асууж, тайлбар, тодорхойлолт гаргуулах, маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой бичиг баримт, бусад мэдээллийг шаардан гаргуулах, маргааныг бүрэн гүйцэд, бодитой шийдвэрлэхэд шаардагдах бусад бэлтгэл ажиллагааг хийх зэрэг маш тодорхой арга хэмжээг зохион байгуулах үүрэгтэй. Энэ нь илтгэгч гишүүн зөвхөн тайлбараа ирүүлэхийг холбогдох этгээдээс хүсээд орхих бус маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай бүхий л мэдээллийг шинжлэн, судлах зохицуулалт юм.

Түүнчлэн, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Цэцийн гишүүн маргааныг Цэцийн хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэл ажиллагааг дууссан гэж үзвэл түүнийг Цэцийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлэх тухай тогтоол гаргана.” гэж заасан бөгөөд Монгол Улсын Их Хурлаас тухайн хуулийн талаарх итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбар ирүүлээгүй байхад хуралдааныг зарлах бэлтгэл бүрэн хангагдсан гэж үзэх боломжгүй юм.

Түүнчлэн, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Энхбаяр хүндэтгэн үзэх шалтгаанаа дурдаж Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг хойшлуулах хүсэлтээ өгсөөр байтал Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Маргагч

тал хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирээгүй бөгөөд өөрөө заавал биечлэн оролцох хүсэлтээ албан ёсоор мэдэгдсэн бол хуралдааныг хойшлуулах тухай магадлал гаргаж, түүнд уг хуралдааныг хийх хугацааг заах буюу тийм боломжгүй бол дараа зарлахаар тогтооно.” гэснийг харгалзан үзэлгүй дунд суудлын хуралдааныг зохион байгуулсан нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан гэж үзэх нөхцөл бүрдсэн байна.

***Тав.Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлагыг Монгол Улсын шүүхийн тухай хуульд тусгасныг харгалзан үзээгүй талаар***

Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хороог бүрдүүлэхэд парламентыг зохист хэмжээнд оролцуулах нь ардчилсан улсын мөн чанарт тохирно гэж олон улсад үздэг. Тухайлбал, Венецийн комиссоос “Ардчилсан зарчмаар зохион байгуулагдсан тогтолцоонд Шүүхийн зөвлөл<sup>4</sup> нь парламентаар дамжин илэрхийлэгддэг ард түмний хүсэл зоригийн төлөөлөлтэй холбогдсон байх хэрэгтэй.”<sup>5</sup> Шүүхийн зөвлөлийн шүүгч бус гишүүдийг бүрдүүлэхэд парламент чухал үүрэгтэй оролцох нь зүй ёсны хэрэг. Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалахын тулд Шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүний гол хэсгийг шүүгчид дотроосоо сонгох, шүүхийн зөвлөлийн ардчилсан легитим шинжийг хангахын тулд бусад гишүүдийг парламентаас сонгох ёстой гэж Венецийн комисс зөвлөсөн<sup>6</sup> байдаг. Түүнчлэн, Шүүхийн зөвлөл бүхий Испани, Итали зэрэг улсад уг зөвлөл дахь шүүгч гишүүдийг шүүгч нар нь сонгох, шүүгч бус гишүүдийг нь парламент дийлэнх олонхоор томилдог жишгийг харгалзан Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д тусгасан.

Парламент нь нийт иргэдийг төлөөлж байдгийн хувьд Шүүхийн зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилж болох ч парламент дахь олонхын хэт нөлөөг сааруулж улс төрийн оролцоог багасгахын тулд цөөнхийн болон бусад талын бодит оролцоог хангах нь шүүх эрх мэдлийг хараат бус байлгах үндэс юм. Олон талын оролцоог тэнцвэртэй хангах зорилгоор гурван төрлийн аргаас улс орнууд сонгон хуульчилж байна. Эхний арга нь Шүүхийн

<sup>4</sup>“Шүүхийн зөвлөл” гэх нэр томъёоны хүрээнд Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн эсхүл Шүүхийн сахилгын хорооны аль алийнх нь чиг үүрэг гүйцэтгэдэг байгууллагыг ойлгодог.

<sup>5</sup>CDL-INF(1998)009, Opinion on recent amendments to the law on major constitutional provisions of the Republic of Albania, §§9, 19; CDL-AD(2002)026, Opinion on the Draft Law on Judicial Power and Corresponding Constitutional Amendments of Latvia, §13; CDL-AD(2014)008, Opinion on the draft Law on the High Judicial and Prosecutorial Council of Bosnia and Herzegovina, §§43-45.

<sup>6</sup>European commission for democracy through law (the Venice Commission), “Judicial appointments” (Venice, 16-17 March 2007), 7.



зөвлөлийн шүүгч бус гишүүдийг парламентын дийлэнх олонхын санал (гуравны хоёр, дөрөвний гурав гэх мэт)-аар сонгох.<sup>7</sup> Дийлэнх олонхын томилгоо нь сонгуулийн холимог, эсхүл пропорциональ тогтолцоотой улсад тохирдог. Харин сонгуулийн мажоритар тогтолцоотой улсад нэг нам дийлэнх олонхыг бүрдүүлэх боломжтой учраас цөөнхийн болон бусад институцийн оролцоог хангахгүйгээр шийдвэр гаргахаас сэргийлэхэд бэрхшээл үүсдэг учраас шүүгч бус гишүүдийн тавин хувийг парламентын олонхоор, үлдсэн тавин хувийг парламентын цөөнхөөр томилуулах замаар<sup>8</sup> шийддэг. Энэ нь цөөнхийн оролцоог бодитой хангах ч хэт улс төржиж талцах эрсдэлтэй. Гурав дахь арга нь олон институциас бүрдсэн Ажлын хэсгээр сонгон шалгаруулалтыг хараат бусаар зохион байгуулах нь шударга, хараат бус сонголтыг бий болгодог гэж үздэг.

Түүнчлэн, Шүүхийн зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэхэд Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, их сургууль, төрийн бус байгууллага зэрэг бие даасан байгууллагуудыг албан ёсоор татан оролцуулж, сонгон шалгаруулалтыг тусгайлан байгуулсан Ажлын хэсгээр гүйцэтгүүлэх зөвлөмжийг Венецийн комиссоос удаа дараа гаргаж ирсэн<sup>9</sup> зэргийг судлан үзэж, гурав дахь аргыг Монгол Улсад тохирох хувилбар гэж үзэн Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д тусгасан.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

<sup>7</sup>European commission for democracy through law (the Venice Commission), “Judicial appointments” (Venice, 16-17 March 2007), 7; Venice Commission, Opinion on the Draft Law on Amendments to the Judicial System Act of Bulgaria, CDL-AD (2002) 015, para. 5; European Network of Councils for the Judiciary (ENCJ), Project on Non Judicial Members in Judicial Governance 2015-2016, 11.

<sup>8</sup>CDL-INF(1998)009, Opinion on recent amendments to the law on major constitutional provisions of the Republic of Albania., §19

<sup>9</sup>European Commission For Democracy Through Law (Venice Commission) Bulgaria Opinion On The Judicial System Act, CDL-AD(2017)018, 7; European Commission For Democracy Through Law (Venice Commission), Final Opinion On The Revised Draft Constitutional Amendments On The Judiciary, CDL- AD(2016)009, 5.











խնայող փոփոխումներ և խնայող ռազմավարական քայլերն անհրաժեշտ է համարել պետության կայուն զարգացման և քաղաքական, տնտեսական և սոցիալական կայունության հիմքը:

Հետևաբար, նախագիծը կարող է լինել նախագիծը կայուն զարգացման համապատասխանող արևմտաեվրոպական ճանապարհի վերականգնման ժամանակակից արժանատի օրինակ:

Արևմտաեվրոպական ճանապարհի և արևմտաեվրոպական մոդելի մասին խոսելիս, հետազոտողները կարող են հանդիպել նախագիծը կայուն զարգացման համապատասխանող արևմտաեվրոպական ճանապարհի մասին խոսելիս, որի մեջ ներկայից կարող է մտնել արևմտաեվրոպական ճանապարհի մոդելի արժանատի օրինակը: Այսինքն, նախագիծը կարող է լինել նախագիծը կայուն զարգացման համապատասխանող արևմտաեվրոպական ճանապարհի վերականգնման ժամանակակից արժանատի օրինակ:

6. Արևմտաեվրոպական ճանապարհի մոդելի վերականգնման համապատասխանող արևմտաեվրոպական ճանապարհի մոդելի արժանատի օրինակ:

Ինչպես արևմտաեվրոպական ճանապարհի մոդելի վերականգնման ժամանակակից արժանատի օրինակ, այսինքն, նախագիծը կարող է լինել նախագիծը կայուն զարգացման համապատասխանող արևմտաեվրոպական ճանապարհի վերականգնման ժամանակակից արժանատի օրինակ:

Այսինքն, նախագիծը կարող է լինել նախագիծը կայուն զարգացման համապատասխանող արևմտաեվրոպական ճանապարհի մոդելի արժանատի օրինակ: Այսինքն, նախագիծը կարող է լինել նախագիծը կայուն զարգացման համապատասխանող արևմտաեվրոպական ճանապարհի վերականգնման ժամանակակից արժանատի օրինակ:

Այսինքն, նախագիծը կարող է լինել նախագիծը կայուն զարգացման համապատասխանող արևմտաեվրոպական ճանապարհի մոդելի արժանատի օրինակ: Այսինքն, նախագիծը կարող է լինել նախագիծը կայուն զարգացման համապատասխանող արևմտաեվրոպական ճանապարհի վերականգնման ժամանակակից արժանատի օրինակ:

Այսինքն, նախագիծը կարող է լինել նախագիծը կայուն զարգացման համապատասխանող արևմտաեվրոպական ճանապարհի մոդելի արժանատի օրինակ: Այսինքն, նախագիծը կարող է լինել նախագիծը կայուն զարգացման համապատասխանող արևմտաեվրոպական ճանապարհի վերականգնման ժամանակակից արժանատի օրինակ:











palīdzību, lai nodrošinātu labvēlīgus apstākļus mācīšanās procesam. Bērniem jānodrošina iespēja izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana.

veikšana, lai nodrošinātu labvēlīgus apstākļus mācīšanās procesam. Bērniem jānodrošina iespēja izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana.

veikšana, lai nodrošinātu labvēlīgus apstākļus mācīšanās procesam. Bērniem jānodrošina iespēja izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana.

veikšana, lai nodrošinātu labvēlīgus apstākļus mācīšanās procesam. Bērniem jānodrošina iespēja izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana. Mācītājam jānodrošina bērniem iespēju izvēlēties, kādas darbības veikt, kā arī piedalīties tādās aktivitātēs, kurās ir jānodrošina bērnu veiktspēju veicinošs vides radīšana.











## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2021 оны 04 дүгээр  
сарын 28-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын шүүхийн тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны  
танхим 15.35 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Г.Туулхүү даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Солонго, Ш.Солонго, Ц.Нанзаддорж /илтгэгч/, Г.Баясгалан нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд хүсэлт гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Отгонбаяр, А.Эрдэнэцогт нар оролцов. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хүрэлцэн ирээгүй болно.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 25 дугаар зүйлийн 25.8.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.3, 30.4 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1, 36.4, 36.5, 36.7, 36.8, 36.9, 36.10 дахь хэсэг, 56 дугаар зүйлийн 56.9 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсгийн зарим заалт, мөн зүйлийн 76.3 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1-77.11 дэх хэсэг, 95 дугаар зүйлийн 95.4, 95.5 дахь хэсгийн зарим заалт, мөн зүйлийн 95.3, 95.7 дахь хэсэг, 101 дүгээр зүйлийн 101.5 дахь хэсэг, 105 дугаар зүйлийн 105.8 дугаар хэсэг, 110 дугаар зүйлийн 110.6, 110.7 дахь хэсэг, 112 дугаар зүйлийн 112.8 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

***Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга Үндсэн хуулийн цэцэд хандан гаргасан хүсэлтдээ:***

“... Монгол Улсын шүүхийн тухай хуульд туссан хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэл хоорондоо харилцан тэнцвэртэй байх Үндсэн хуулийн тулгуур зарчмыг бүрэн алдагдуулсан, “шүүх бие даасан, шүүгч хараат бус байх” Үндсэн хуулийн суурь зарчмыг илэрхий зөрчсөн, Улсын Их Хуралд Үндсэн хуулийн бус эрхийг олгох замаар хууль тогтоох эрх мэдлээс шүүх эрх мэдэлд нөлөөлөх, дарангуйлах нөхцөлийг илтэд бүрдүүлсэн, эрх мэдлийн тэнцвэрийг хангахад голлох үүрэгтэй Монгол Улсын Ерөнхийлөгчийн шүүх эрх мэдлийн хүрээн дэх үндсэн бүрэн эрхийг үндэслэлгүйгээр хязгаарласан зэрэг ноцтой үр дагавар бүхий Үндсэн хуульд нийцээгүй тодорхой зүйл, заалтуудыг Үндсэн хуулийн цэцээр хянуулах нь зүйтэй гэж үзлээ.

1.Монгол Улсын шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-ийн /цаашид “Хууль” гэх/ 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсэгт “... бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно.” гэсэн нь, 77 дугаар зүйлийн 77.1-77.11 дэх хэсэг, 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэгт “... Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно. ...” гэсэн нь, мөн зүйлийн 95.5 дахь хэсгийн хоёр дахь өгүүлбэр, 95.7 дахь хэсэг нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 5, 6 дахь хэсэг, Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 6 дахь заалт, Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн холбогдох зүйл, заалтад тус тус нийцэхгүй байна:

а/ Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5, 6 дахь хэсгийн зорилго, агуулга нь Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хороог эрх мэдлийн харилцан тэнцвэртэй байх зарчимд нийцүүлэн аль нэг эрх мэдэлд давамгайл байдал олгохгүй байх агуулгаар зохицуулахад чиглэсэн. Учир нь шүүхийн боловсон хүчин, шүүгчийн сахилга, хариуцлагын асуудлыг хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын аль нэгний мэдэлд шууд өгвөл шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал бүрэн алдагдана.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар



тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 3.1.1-д “Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, хараат бус, тогтвортой байдлыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүний тавыг шүүгчид дотроосоо хувь тэнцүүлэн сонгож, бусад таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох, ...” гэж, мөн 3.2.3-т “Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг ... холбогдох институцээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх зарчмыг хуульчлах” гэж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн утга агуулгыг дэлгэрүүлэн заажээ. Энэ бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан зөвшилцлийн гол агуулга болно.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дээрх зохицуулалтуудаар Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хороог хууль тогтоогч өөрийн мэдэлдээ бүрэн авсан нь Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5, 6 дахь хэсгийг илэрхий зөрчиж байна. Ингэснээр хууль тогтоогч шүүхийн боловсон хүчин, шүүгчийн сахилга, хариуцлагын асуудлыг хариуцсан Үндсэн хуулийн институтыг төрийн аль нэг эрх мэдлээс хараат бус байлгах чиглэлээр түүний эрх зүйн үндсийг бүрдүүлэх Үндсэн хуулиар хүлээсэн үүргээ умартаж, Үндсэн хуулиар өөрт /Улсын Их Хуралд/ олгогдоогүй эрх мэдлийг хуульчлан авах зэргээр хууль тогтоох эрх мэдлийг явцуу зорилгоор хэрэгжүүлж, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн шүүх эрх мэдэлтэй холбогдох хэсгийн зорилго, агуулгыг бүрэн гажуудуулсан гэж үзэж байна.

б/ Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг Улсын Их Хурлын даргын захирамжаар, Улсын Их Хурлын гишүүнээр ахлуулан байгуулсан улс төрийн шууд оролцоотой ажлын хэсгээс санал болгох замаар Улсын Их Хурал дангаар томилох нь шүүхийн боловсон хүчний бодлого, мөн түүнчлэн шүүхийн сахилга хариуцлагын асуудал улс төрийн нөлөөнд шууд автагдаж, үүний улмаас шүүх эрх мэдлийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал бүрэн алдагдах нөхцөл бүрдэж байна.

в/ Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг нэр дэвшүүлэх ажлыг төрийн эрх мэдлийн нэг институт өөрөө эрхэлж сонгон шалгаруулаад, томилдог олон улсын жишиг байхгүй байна. Монгол Улс шүүхийн захиргааг бий болгон ажиллуулж ирсэн түүхэндээ Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг эрх мэдлийн нэг институтээс хараат болгон дангаар томилж байгаагүй байна. Энэ бүгдээс

үзвэл Улсын Их Хурал шүүхийн захиргаа, шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулж томилох эрхийг өөрт авсан нь Улсын Их Хурлын хууль тогтоох чиг үүрэгт нийцэхгүй төдийгүй Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн, олон улсын болон өөрийн орны хөгжиж ирсэн практикт гараагүй гажуудлыг бий болгох эрсдэлийг үүсгэж, цаашид Үндсэн хуульд заасан шударга ёс, тэгш байдлын зарчим алдагдаж, эрх чөлөөт байдал хуулийн замаар дарангуйлагдах үндэс суурийг тавьсан гэж үзэж болно.

2.Хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.3, 30 дугаар зүйлийн 30.3, 30.4 дэх хэсэгт эрүү, иргэний хэргийн анхан болон давж заалдах шатны шүүхийг тухайн шатанд нь дахин нэгтгэн, дотор нь эрүү, иргэний хэргийн чиглэлээр танхимтай байж болохоор зохицуулсан нь хүрсэн түвшингээс ухарч буй буруу шийдэл бөгөөд Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт нийцэхгүй юм. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж ирсэн өмнөх ололтыг бататган бэхжүүлж улам боловсронгуй болгох ёстой. Шүүхийг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулах нь иргэн зөрчигдсөн эрхээ тухайн маргааныг харьяалах дагнасан шүүх, мэргэшсэн шүүгчээр шүүлгэх замаар хууль ёсны шүүхээр шүүлгэх эрхээ эдлэх боломж бөгөөд энэ талаар хүрсэн түвшин, олсон ололтыг бууруулж болохгүй.

3.Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.8, 36.9, 36.10 дахь хэсэгт Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс бусад шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүнийг тухайн шатны шүүхийн болон танхимын шүүгчид дотроосоо сонгодог байхаар зохицуулсан нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт нийцэхгүй байна. Үндсэн хуулиар Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс бусад шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүн нь тухайн шатны шүүхийн болон танхимын шүүгчид дотроосоо сонгогдсоноор бүрэн эрх нь баталгаажих эрх зүйн үндэслэл байхгүй юм. Улсын Дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгч, танхимын тэргүүнийг ур чадвар, туршлагыг нь харгалзан тодорхой болзол, шалгуурын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөл сонгон шалгаруулж, Улсын Дээд шүүхийн танхимын тэргүүнийг тухайн танхимын шүүгчид дотроосоо санал болгож тус тус Үндсэн хуулийн дагуу томилох нь зөв бөгөөд хууль ёсны болно гэж үзэж байна. Хуулийн 36 дугаар зүйлийн 36.9 дэх хэсэгт "... Ерөнхий шүүгчийг сонгоогүй бол шүүгчээр хамгийн олон жил ажилласан шүүгчийг гурван жилийн хугацаагаар тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс томилно." гэж улам завхруулсан байна.



4.Хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.4, 36.5, 36.7 дахь хэсэгт бүх шатны шүүхийн шүүгч болон Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгч 14 хоногийн дотор томилохоор үүрэгжүүлсэн нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийн агуулгад нийцэхгүй байна. Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх нь зөвхөн үүрэг байх агуулгаар хязгаарлагдахгүй юм.

5.Хуулийн 56 дугаар зүйлийн 56.9 дэх хэсэгт “Сахилгын хороо шүүгчийг огцруулсан бол Ерөнхийлөгчид танилцуулна.” гэж заасан нь Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт нийцэхгүй байна. Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд нийцүүлэн гаргасан зарлигаа өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэнэ.

6.Хуулийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуульч бус гишүүнд нэр дэвшигч нь эрх зүйч мэргэжилтэй байхаар заасан нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн чиг үүрэг, эрхлэх асуудалд тохирохгүй бөгөөд Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэгт нийцэхгүй байна. Мөн Хуулийн 95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсэгт Шүүхийн сахилгын хорооны хуульч бус гишүүнд нэр дэвшигч нь эрх зүйч мэргэжилтэй байхаар заасан нь Шүүхийн сахилгын хорооны чиг үүрэг, эрхлэх асуудалд тохирохгүй бөгөөд Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт нийцэхгүй байна.

Энэ нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрхгүй этгээд буюу хуульч биш хүнээр шүүгчийн зарим мэргэжлийн алдааг дүгнэх, улмаар шүүгчид хариуцлага тооцох эрх мэдэл олгож, үүрэг, хариуцлага хүлээлгэх үр дагавартай байна. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны шүүгч гишүүд нь хуульч, шүүгч бус гишүүд нь эрх зүйч байх нь тухайн бүрэлдэхүүний ижил тэгш, адил ур чадвартай байх нөхцөлийг алдагдуулж байна.

Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”- ийн 3.1.1-д “Шүүхийн ерөнхий зөвлөлийн ... шүүгч бус 5 гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох, ...”, 3.2.3-т “Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг шүүн таслах ажлын туршлагатай хуульчид, нэр хүндтэй иргэд, хууль зүйн өндөр мэргэшилтэй эрдэмтдээс нээлттэй

нэр дэвшүүлэх замаар холбогдох институтээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх зарчмыг хуульчлах” гэж тус тус заасан. Тиймээс хуулийн 76 дугаар зүйлийн 76.3, 95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсэг нь мөн Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчиж байна.

7.Хуулийн 101 дүгээр зүйлийн 101.5 дахь хэсэг, 105 дугаар зүйлийн 105.8 дахь хэсэг, 110 дугаар зүйлийн 110.6, 110.7 дахь хэсэг, 112 дугаар зүйлийн 112.8 дахь хэсэгт Шүүхийн сахилгын хороонд хандан өргөдөл, гомдол гаргагчийг хэргийн оролцогч гэж үзэлгүй зөвхөн гэрч, ажиглагч гэж заасан нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалтад нийцэхгүй байна. Гомдол, мэдээлэл гаргагч нь сахилгын зөрчил хэрхэн шалгагдаж байгаа болон хэрэгт авагдсан нотлох баримттай танилцах, сахилгын хороонд хандан хүсэлт гаргах, сахилгын хорооны шийдвэрт гомдол гаргах, бүрэлдэхүүнийг татгалзан гаргах зэрэг эрхтэй байж сахилгын зөрчил маргаан шударгаар шийдвэрлэгдэх нөхцөл бүрдэнэ.

Иймд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн дээрх зүйл, хэсэг, заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн болохыг хянан шийдвэрлэж өгнө үү.” гэсэн байна.

### **ҮНДЭСЛЭЛ:**

1.Монгол Улсын Их Хурал 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийг “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэж, Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийг “Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.” гэж өөрчлөн найруулж, мөн зүйлийн 6 дахь хэсэгт



“Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.” гэсэн зохицуулалтыг нэмсэн байна.

2. Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийг мөн 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталж, 1 дүгээр зүйлд “... Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгана.” гэж заасан байна. Энэ хүрээнд Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоол гарган Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарийг баталсан бөгөөд тус хуваарийн 3.1-д “Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:” гээд 3.1.1-д “Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, хараат бус, тогтвортой байдлыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүний тавыг шүүгчид дотроосоо хувь тэнцүүлэн сонгож, бусад таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох, ...”, мөн 3.2-т “Шүүгчийн хариуцлагыг сайжруулах талаарх нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан боловсруулах хуулийн төсөлд дараах чиглэл баримтална:” гээд 3.2.3-т “Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг ... холбогдох институцээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх зарчмыг хуульчлах.” гэж тус тус заажээ.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталж, уг нэмэлт, өөрчлөлтийн гол үзэл баримтлалыг тодорхойлон дээрх хуваарийг гаргахдаа хууль тогтоомжийг боловсруулан батлахад баримтлах чиглэлийг тусгайлан заасан нь Монгол Улсын шүүхийн тухай хуулийн холбогдох зохицуулалтад заавал тусган хуульчлах агуулгыг илэрхийлсэн гэж ойлгогдож байна.

3. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Монгол Улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтоох зэрэг харилцааг зохицуулах зорилго бүхий Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг баталсан байна.

Дээрх хуулийн 76 дугаар зүйлийн 76.2 болон 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилохоор зааж, 77 дугаар зүйлийн 77.1-77.11 дэх хэсэг, 95 дугаар зүйлийн 95.5, 95.7 дахь хэсэгт гишүүдийг нэр дэвшүүлж, томилох журмыг тогтоож, тэдгээрийг сонгон шалгаруулж, томилох ажиллагаанд хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах журмыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо энэ хуульд нийцүүлэн батлахаар хуульчилжээ.

Үүнээс үзэхэд шүүгчийн хараат бус байх, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилго бүхий Шүүхийн ерөнхий зөвлөл болон шүүгчийн сахилга хариуцлагын асуудлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг тус тус Улсын Их Хурал дангаар томилохоор Монгол Улсын шүүхийн тухай хуульд тусгасан байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтоох нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэгт зааснаар хууль тогтоогчийн бүрэн эрхийн хүрээнд хамаарах хэдий ч ийнхүү хуульчлахдаа Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын хүрээнд тодорхойлогдсон Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус бусад таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох талаарх чиглэлийг баримтлаагүй гэж үзэхээр байна. Ингэснээр шүүх эрх мэдлийн байгууллагын хараат бус байдал болон Үндсэн хуулиар баталгаажсан төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг алдагдуулах нөхцөлийг бүрдүүлж, Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 5, 6 дахь хэсгийг зөрчсөн байна.

Түүнчлэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тайлан, мэдээллээс харахад Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн ёс зүйн хорооны гишүүдийн тодорхой хувь нь орон тооны бусаар ажиллаж байжээ. Харин Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон чиг үүргийн хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөл сүүлийн 10 жилийн дунджаар нэг жилд 26 шүүгчийг /зарим жилд 2 шүүгчийг/ санал болгож байсан бол, Шүүхийн ёс зүйн хороо нь сүүлийн 8 жилийн дунджаар нэг жилд 307 гомдлыг хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс үзэхэд хууль тогтоогч Шүүхийн ерөнхий



зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүний эрх зүйн байдлыг тогтооходоо дээр дурдсан туршлагыг харгалзан үзэх шаардлагатай байгааг тэмдэглэх нь зүйтэй.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.” гэж зааж бүх шатны шүүхийн шүүгчийг томилох бүрэн эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгосон байх бөгөөд мөн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргахаар тогтоосон байна. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.7 дахь хэсэгт анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар, мөн Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүх санал болгосноос хойш Ерөнхийлөгч тус тус 14 хоногийн дотор томилохоор заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтыг зөрчсөн гэх үндэслэлгүй байх ба тодорхой хугацаа тогтоосон асуудал нь Үндсэн хуулийн маргааны шинжийг агуулаагүй байна.

Мөн Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.8, 36.9 дэх хэсэгт анхан, давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс нууц санал хураалтаар гурван жилийн хугацаагаар сонгохоор, Ерөнхий шүүгчийг сонгоогүй бол шүүгчээр хамгийн олон жил ажилласан шүүгчийг тухайн шүүхийн Зөвлөгөөнөөс томилохоор, түүнчлэн мөн зүйлийн 36.10 дахь хэсэгт танхимын тэргүүнийг тухайн шүүхийн зөвлөгөөн дотроосоо нууц санал хураалтаар, гурван жилийн хугацаагаар сонгохоор зохицуулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчөөгүй, Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд халдсан гэж үзэх үндэслэлгүй байна.

Түүнчлэн Ерөнхий зөвлөлийн санал болгосон нэр дэвшигчийг шүүгчид тавигдах шаардлага хангаагүй гэх үндэслэлээр Ерөнхийлөгчөөс буцаах, уг буцаасан саналыг Ерөнхий зөвлөл дахин нягталж санал болгох,

эсхүл өөр нэр дэвшигчийг санал болгохоор заасан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.4, 36.5 дахь хэсэг нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

5.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг хуулиар тогтооно гэж заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэгт “Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.” гэж хуульчилсан байна. Дээрх шаардлага нь Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцсэн байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4, 5, Жаран есдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

6.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд тавигдах шаардлагыг хуулиар тогтооно гэж заасны дагуу Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсэгт “Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгч гишүүн нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан, сахилгын шийтгэлгүй, бусад гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрээгүй, сүүлийн таван жил шүүгч, улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.” гэж хуульчилжээ. Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг шүүгч болон шүүгч бус /эрх зүйч/ гишүүдээс бүрдүүлэхээр ийнхүү зохицуулсан нь шүүгчийн ёс зүй, сахилга хариуцлагын асуудалд тавих хяналт бодитой бөгөөд харилцан тэнцвэртэй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6, Жаран есдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

7.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.2 дахь заалт, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.3, 30.4



дэх хэсэгт анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүх тус бүр шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнасан танхимтай байж болох бөгөөд энэхүү асуудлыг тухайн шатны шүүгчдийн зөвлөгөөний саналыг үндэслэн Улсын дээд шүүх шийдвэрлэхээр нийтлэг байдлаар зохицуулжээ. Мөн уг хуулийн 56 дугаар зүйлийн 56.9 дэх хэсгийн зохицуулалтын талаарх хүсэлтийн үндэслэл нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудалд хамаарч байна.

Иймд дээр дурдсан асуудлын хүрээнд Үндсэн хуулийн цэцээс дүгнэлт гаргах боломжгүй байна. Харин хууль тогтоогч холбогдох зохицуулалтыг боловсронгуй болгох, Шүүх байгуулах тухай хуулийг шинэчлэн батлахдаа анхаарах нь зүйтэй байна.

8.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.5, 105 дугаар зүйлийн 105.8, 110 дугаар зүйлийн 110.6, 110.7, 112 дугаар зүйлийн 112.8 дахь хэсэгт шүүгчид холбогдох сахилгын хэрэг хянан шийдвэрлэх журам болон оролцогчдын эрх зүйн байдлын талаарх зохицуулалтыг тусгасан байх ба Үндсэн хуулийн холбогдох заалтаар баталгаажсан иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхийг хязгаарлаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсэгт "... бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно.", 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэгт "... Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно. ...", 95.5 дахь хэсэгт "... Улсын Их Хурал энэ хуулийн 77.1, 77.2, 77.3, 77.4, 77.5, 77.6, 77.7, 77.8, 77.9, 77.10-т заасан журмыг баримтлан Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулж, томилно." гэж заасан нь; мөн хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-77.11 дэх хэсэг, 95 дугаар зүйлийн 95.7 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 3, 5, 6 дахь хэсгийг тус тус зөрчсөн байна.

2.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсэг, 95 дугаар зүйлийн 95.4, 95.5 дахь хэсгийн холбогдох заалт, мөн хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-77.11 дэх хэсэг, 95 дугаар зүйлийн 95.7 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйл, Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 6 дахь заалт, Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

3.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 36 дугаар зүйлийн 36.8, 36.9, 36.10 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчөөгүй байна.

4.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.4, 36.5, 36.7 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчөөгүй байна.

5. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь хэсэг, 95 дугаар зүйлийн 95.3 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 4, 5, 6, Жаран есдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

6.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.5 дахь хэсэг, 105 дугаар зүйлийн 105.8 дахь хэсэг, 110 дугаар зүйлийн 110.6, 110.7 дахь хэсэг, 112 дугаар зүйлийн 112.8 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалтыг зөрчөөгүй байна.

7.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсэгт “... бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно.”, 95 дугаар зүйлийн 95.4 дэх хэсэгт “... Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох бусад таван гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно. ...”, 95.5 дахь хэсэгт “... Улсын Их Хурал энэ хуулийн 77.1, 77.2, 77.3, 77.4, 77.5, 77.6, 77.7, 77.8, 77.9, 77.10-т заасан журмыг баримтлан Сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулж, томилно.” гэж заасныг; мөн тус хуулийн 77 дугаар зүйлийн 77.1-77.11 дэх хэсэг, 95 дугаар зүйлийн 95.7 дахь хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн тус тус түдгэлзүүлсүгэй.





8.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Г.ТУУЛХҮҮ**

**ГИШҮҮД**

**Д.СОЛОНГО  
Ш.СОЛОНГО  
Ц.НАНЗАДДОРЖ  
Г.БАЯСГАЛАН**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [tugiin\\_medeel@parliament.mn](mailto:tugiin_medeel@parliament.mn)

**Утас: 262420**

Хэвлэлийн хуудас: 2.75

**Индекс: 200003**